

Аюултай энерги!

2018 оны 10-р сар

2018 оны 4-р сарын 17-нд Пенсилваны зүүн хэсэгт Нью-Йоркоос Даллас руу нисэж явсан зорчигч тээврийн онгоцны зүүн хөдөлгүүрт ноцтой эвдрэл үүссэн. Хөдөлгүүрийн дотор тал болон урд хаалтын (1) хэлтэрхий хэсгүүд онгоцны далавч (2) ба их биеийг цохиж, их хэмжээний гэмтэл учруулсан. Зорчигч талын (3) нэг цонх хагарч, салсанаар зорчигчийн кабины даралт хурдан буурсан. Нисэх багийн гишүүд онгоцыг яаралтай буулгах арга хэмжээ авч, Филадельфт газардаж чадсан. Нэг зорчигч амь насаа алдахад хүргэсэн гэмтэл, найман зорчигч бага зэргийн бэртэл авсан. АНУ-ын Үндэсний Тээврийн АА-ны Зөвлөл (NTSB)-ийн урьдчилсан мэдээллээр онгоцны нэг хөдөлгүүрийн сэнс нь гэмтэж, төмөр уярч элэгдсэн шинж чанартай ижил гэмтэл байсныг онцолсон.

Тийрэлтэд хөдөлгүүрийн сэнс нь өндөр хурдтай эргэлдэгч төхөөрөмж бөгөөд маш их кинетик энерги(хөдөлгөөний энерги) агуулдаг. Хэрэв энд доголдол үүсвэл төмрийн хэлтэрхий хэсэг их хэмжээний гэмтэл үүсгэх ба хол зайнд харваж чаддаг. Ихэнхи боловсруулах үйлдвэрүүд өндөр хурдтай эргэлдэгч төхөөрөмжтэй байдаг – жишээ нь: компрессор, центрфуг, холигч. Ийм төхөөрөмжинд тийрэлтэд хөдөлгүүрийн доголдолтой адил гэмтэл үүсч болно. Үйлдвэрлэлийн АА-ны Удирдлагын Систем нь эдгээр аюулыг таних, өндөр энергитэй тоног төхөөрөмжийн загвар, үйлдвэрлэл, үзлэг, засвар үйлчилгээний гүйцэтгэлийг шаардлагыг хангах системтэй байх ёстой.

Тайлбар зураг: АНУ-ын Үндэсний Тээврийн АА-ны Зөвлөлийн Судалгааны шинэчилсэн мэдээлэл, Southwest Airlines Flight 1380 Engine Failure, DCA18MA142 SWA1380 (<http://www.ntsb.gov/investigationreports/2018011380main.pdf>).



Та үүнийг мэдэх үү ?

Бид ихэнхдээ үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа нь аюултай материалыг хянах тухай гэж ойлгодог. Энэ нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны чухал хэсэг боловч аюултай энергийг хянах нь мөн чухал байдаг. Таны ажиллаж буй үйлдвэрт байж болох аюултай энергийн зарим жишээнээс дурдвал:

- Насос, компрессор, сэнс, центрфуг, холигч, шахагч г.м өндөр хурдтай эргэлдэгч тоног төхөөрөмжөөс гарах кинетик энерги.
- Цахилгаан энерги
- Даралтад агаар, бусад хий, өндөр даралтын уур г.м өндөр даралтын энерги
- Өндөр температур
- Хүндийн хүчний потенциал энерги – жнь: аюултай материал агуулаагүй байсан ч дүүрэн шингэн агуулсан том танк нурвал маш их хохирол учруулна. 1919 онд Бостонд хар бурамтай танк сав задарч, хотын хэсгээр урсах материал 5 м өндөртэй давалгаан үүсгэж, 21 хүн амь насаа алдан, 150 гаруй хүн бэртэхэд хүргэсэн. (May 2007 *Beacon*).

Та юу хийж чадах вэ ?

- Хамтран ажиллагсадтайгаа өөрийн үйлдвэрт байж болох аюултай энергийн эх үүсвэрийг жагсаан бич. Эдгээр аюулуудтай холбоотой эрсдлийг хянах хэрэгжиж буй ашиглалт, үзлэг болон урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний системүүдийг бүгд ойлгож байгааг анхаарах.
- Өөрийн үйлдвэрийн аюултай энергийн хамгаалалт зөв, тохиромжтой ажиллагаатай байгааг няглахад ямар үүрэг хариуцлагатай байгааг ойлгох.
- Өндөр хурдаар ажилладаг олон тоног төхөөрөмжүүдэд чичиргээний эсвэл зогсоох хоригтой чичиргээний мэдрэгчтэй байдаг. Үүнийг үйлдвэрийн түр хугацааны өөрчлөлтийн менежментийн (MOC) журмыг мөрдөхгүйгүйгээр хийх ёсгүйг анхаарах.
- Хэрэв та аюултай энергитэй тоног төхөөрөмжинд үзлэг, засвар үйлчилгээ хийх үүрэгтэй бол тусгай заасан журмуудыг чандлан мөрдөж, мэдээлэх ёстой аливаа асуудлыг өөрийн удирдлага болон техник үйлчилгээний багт мэдэгдэж байх

Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа нь аюултай материал БОЛОН энергийг хянана!